



ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН САРЫН ТОЙМ МЭДЭЭ 2012 оны 03 сар

Энэ сард нийт 21 удаагийн арилжаагаар 111 компанийн 4.5 сая ширхэг хувьцаа арилжиж, нийт 2.8 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна.

Хувьцааны арилжааны үнийн дүн өмнөх сараас 192.8 сая төгрөгөөр буюу 7.2 хувиар өсч, өнгөрсөн оны мөн үеэс 10.8 тэрбум төгрөгөөр буюу 79.3 хувиар буурсан байна. Арилжигдсан хувьцааны тоо ширхэг өмнөх сараас 2.7 сая ширхэгээр буюу 37.2 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 5.9 сая ширхэгээр буюу 56.7 хувиар тус тус буурсан байна.

Хувьцааны арилжаа

“Ремикон” ХК-ийн 2.0 сая ширхэг, “Гермес центр” ХК-ийн 619.3 мянган ширхэг, “Хөх ган” ХК-ийн 399.6 мянган ширхэг, “Женко тур бюру” ХК-ийн 360.9 мянган ширхэг, “Оллоо” ХК-ийн 308.7 мянган ширхэг хувьцааг арилжсан нь хамгийн их арилжигдсан үнэт цааснууд юм. Арилжааны үнийн дүнгээр “Таван толгой” /454.1 сая төгрөг/, “Ремикон” /398.3 сая төгрөг/, “АПУ” /353.1 сая төгрөг/, “Сүү” /312.7 сая төгрөг/ “Шарын гол” /204.8 сая төгрөг/ ХК-ийн үнэт цааснууд идэвхтэй арилжигджээ.

Нэг удаагийн арилжаагаар дунджаар 135.0 сая төгрөгийн гүйлгээ хийж, 214.8 мянган ширхэг хувьцаа арилжсан байна.

Засгийн газрын бондын арилжаа

Энэ сард Засгийн газрын бондын арилжаа явагдаагүй байна.

Компанийн бондын арилжаа

“Жаст агро” компанийн гаргасан “Монгол мах” бондын хоёрдогч зах зээлийн арилжаагаар 17.4 мянган ширхэг бондыг 174.6 сая төгрөгөөр арилжсан байна.

Үнэт цаасны ханш

Нийт 111 үнэт цаас арилжигдсанаас өмнөх сарын сүүлийн өдрийн хаалтын ханштай харьцуулахад 62 үнэт цаасны ханш өсч, 41 үнэт цаасны ханш буурч, 8 үнэт цаасны ханш тогтвортой байлаа.

ТОР-20 индекс

ТОР-20 индекс 20857.51 нэгж байгаа нь өмнөх сараас 800.47 нэгжээр буюу 3.6%-иар, өмнөх оны мөн үеэс 3330.42 нэгжээр буюу 13.76%-иар тус тус буурсан байна.

ТОР-20 индексийн энэ сарын хамгийн дээд үзүүлэлт нь 21747.64 нэгж, доод үзүүлэлт нь 20875.51 нэгж, дундаж үзүүлэлт нь 21527.59 нэгж байна.

ТОР-20 индексийн сагсыг бүрдүүлж байгаа Шивээ овоо (11.1%), Могойн гол (10.8%), Таван толгой (8.7%), Говь (8.0%), Бэрх уул (7.5%), Адуунчулуун (6.8%), Шарын гол (6.3%), Монгол цахилгаан холбоо (5.4%), Багануур (4.8%), Би Ди Сек (4.1%), Ремикон (1.6%), Женко тур бюро (1.1%), Монголиан девелопмент ресурс (1.0%), УИД (1.0%) зэрэг ХК-ийн үнэт цаасны ханш өмнөх сараас тус тус буурсан байна.

Зах зээлийн үнэлгээ

Зах зээлийн нийт үнэлгээ 2 их наяд 25.9 тэрбум төгрөг болж өмнөх сараас 86.1 тэрбум төгрөгөөр буюу 4.0 хувиар, өмнөх оны мөн үеэс 429.3 тэрбум төгрөгөөр буюу 17.4 хувиар тус тус буурсан байна.

Зах зээлийн хамгийн өндөр үнэлгээтэй компанид Таван толгой, АПУ, Багануур, Шивээ овоо, Шарын гол, Бэрх уул, МЦХ, БиДиСек, Говь, УБ БҮК зэрэг компаниуд орж байна. Зах зээлийн үнэлгээ өндөр 30 компанийн үнэлгээ нийт зах зээлийн үнэлгээний 92.3 хувь нь болж байна. Зах зээлийн хамгийн өндөр үнэлгээтэй компани нь “Таван толгой” ХК бөгөөд зах зээлийн үнэлгээ нь 553.0 тэрбум төгрөг болсон байна.